БАТЛАВ

ЗАХИРАЛ С.ОТГОНГЭРЭЛ

**БУЛГАН СУМЫН ЕБС-ИЙН**

**6А АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хувилбар-А Хугацаа: 60 мин

Болжмор

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих час хийв. “Хэн юм шидчихэв ээ” гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. “Хүүе, өвөл яахаараа боргоцой байдаг билээ?” гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

- Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах:
- Хоёулаа үүр хийж өгье орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа, талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан, үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа.

1. Дээрх эхийн гол санааг тодорхойлон бичнэ үү? /1 оноо/

   .................................................................................................................................

   Ах дүү хоёр яагаад болжморт үүр хийж өгсөн бэ? /1 оноо/

   .................................................................................................................................

2. Таамагласан утга бүхий өгүүлбэр аль нь вэ? /2 оноо/

   .............................................................................................................................

3. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, цөм бүтцийг тодорхойлон бичээрэй. /2 оноо/

   Ээж өнөөдөр миний хөөрхөн найзыг гэртээ дуудав.

- .... ............................................................................
- ................................................................................

4. “Хадлан” хэмээх үгийг жинхэнэ нэрийн тийн ялгалаар хувиргаарай. /2 оноо/

| | |
|---|---|
| Нэрлэх- ........................................ | Гарах- ............................................ |
| Харьяалах- .................................. | Үйлдэх- ........................................... |
| Өгөх орших- ................................ | Хамтрах- ........................................ |
| Заах- ............................................ | Чиглэх- .......................................... |

5. Дараах үгийг зөв бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Захь+дал=.......................................

ЗБД:..........................................................................................................................

..................................................................................................................................

..................................................................................................................................

6. Зохиолын хэсгийг уншаад зохиолчийн нэр болон зохиолын нэрийг нөхөөрэй. /5 оноо/

| Зохиолын хэсэг | Зохиолч | Зохиолын нэр |
|---|---|---|
| Эгшин бүрийнд цэгнүүштэй нь<br>Бие, хэл, сэтгэл гурав .... | | |
| ... Дайраад гарах нүүдлийг<br>Ээж минь амдан гүйнэм. | | |
| Ивээлт нарны нь цацрал алтан<br>эрдэнэ .... | | |
| ...Хатируулснаа шогшууллаа<br>Шогшуулснаа алхууллаа. | | |
| ..Монголын үзэсгэлэнт сарангоо ... | | |

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/



.......................................................................................

.......................................................................................

.......................................................................................

.......................................................................................

.......................................................................................

.......................................................................................

Нийт 20 оноо

БАТЛАВ ЗАХИРАЛ С.ОТГОНГЭРЭЛ

**БУЛГАН СУМЫН ЕБС-ИЙН**

**6А АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хувилбар-Б Хугацаа: 60 мин

ЖИНЧИН ДАГАСАН МОГОЙ

Бээжин орохоор говийг туулан жинчид явж байжээ. Нэг өглөө ачаа барааных нь дэргэд нэг могой цагариглан хэвтэж байв. Хэн ч түүнийг сонирхож тоосонгүй. Маргааш нь нэг газар хоноод хөдлөхөд аанай л бас нөгөө могой хэвтэж байв. Хэн ч түүнийг анхаарч үзсэнгүй.

Тав дахь удаа хоноглоод хөдлөх гэж байтал элэг нь улаан нялга болчихсон хөөрхий могой мөлхсөөр орж ирлээ. Хөдлөх гэж байсан жинчид саатаж, тэмээгээ түр хэвтүүлэв. Могой яг л гурав дахь тэмээний хавьд очоод хэвтжээ.

- Энд л нэг учир байна даа гэхэд
- Наадах чинь эх могой байна.

Эцэст нь үр зулзагыг нь бид ачаандаа оруулсныг мэдсэн юм. Нээрээ л тийм байжээ.

1. Эхийн гол санааг илэрхийлэн бичээрэй. /1 оноо/

   ................................................................................................................................

   Могой яагаад жинчдийн ачаа барааны дэргэд хэвтсэн бэ? /1оноо/

   ................................................................................................................................

2. Таамагласан утга бүхий өгүүлбэрийн хэсэг аль нь вэ? /2 оноо/

   ................................................................................................................................

3. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, цөм бүтцийг тодорхойлон бичээрэй. /2 оноо/

   Би өчигдөр аавын дурангаар хөөрхөн янзагуудыг дурандав.

   ................................................................................

   ................................................................................

4. "<u>Морь</u>" хэмээх үгийг жинхэнэ нэрийн тийн ялгалаар хувиргаарай. /2 оноо/

   Нэрлэх- ........................................ Гарах- ............................................

   Харьяалах- .................................. Үйлдэх- ...........................................

   Өгөх орших- ................................. Хамтрах- ........................................

   Заах- ............................................ Чиглэх- ..........................................

5. Дараах үгийг зөв бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Барь+мал=.......................................

ЗБД:........................................................................................................................

.........................................................................................................................

.........................................................................................................................

**6.** Зохиолын хэсгийг уншаад зохиолч болон зохиолын нэрийг нөхөөрэй. /5 оноо/

| Зохиолын хэсэг | Зохиолч | Зохиолын нэр |
|---|---|---|
| Эрт цагт нэгэн эцгийн хоёр хүүхэд холын уулнаас мод түүж ирэхээр явах болжээ. ... | | |
| ... Удам чинь улам олшрог гэж баярлан хашхирав. ... | | |
| ...эцсийн эцэст өөрийн эрхгүй сөгдөн шургачиж хэвтлээ. ... | | |
| Үрийн сайнаар ургаж<br>Үндэсний муугаар ховхорлоо ... | | |
| Хэдэн хүүхдийн минь хайртай ат юм сан | | |

**7.** Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/



........................................................................................

........................................................................................

........................................................................................

........................................................................................

........................................................................................

........................................................................................

Нийт 20 оноо

## Дүгнэх аргачлал:

**1.** Дээрх эхийн гол санааг тодорхойлон бичнэ үү /1 оноо/

- Эхийн гол санааг зөв оновчтой тодорхойлж, бүтэн өгүүлбэрээр хариулсан бол 1 оноо
- Эхийн гол санааг дөхүүлэн тайлбарласан бол 0.5 оноо
- Эхийн гол санааг буруу тайлбарлсан бол 0.5 оноо

А. Ах дүү хоёр яагаад болжморт үүр хийж өгсөн бэ? /1 оноо/

Б. Могой яагаад жинчдийн ачаа барааны дэргэд хэвтсэн бэ? /1 оноо/

- Шалтгааныг оновчтой зөв тодорхойлж бүтэн өгүүлбэрээр хариулсан бол 1 оноо
- Шалтгааныг цөөн үгээр зөв тодорхойлсон бол 0.5 оноо
- Буруу тайлбарласан бол 0 оноо

**2.** Таамагласан утга бүхий өгүүлбэр аль нь вэ? /2 оноо/

- Таамагласан өгүүлбэрийг зөв бичсэн бол 2 оноо
- Таамагласан өгүүлбэрийг дутуу бичсэн бол 1 оноо
- Таамагласан өгүүлбэрийг буруу бичсэн бол 0 оноо

**3.** Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, цөм бүтцийг тодорхойлон бичээрэй. /2 оноо/

А. Ээж өнөөдөр миний хөөрхөн найзыг гэртээ дуудав.

- Ээж найзыг дуудав. 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр хэмээн зөв хариулна.
- Өгүүлбэрийн цөм бүтцийг зөв зурсан бол 1 оноо, зөв тодорхойлсан бол 1 оноо

Б. Би өчигдөр аавын дурангаар хөөрхөн янзагуудыг дурандав.

- Би янзагуудыг дурандав. 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр хэмээн зөв хариулна.
- Өгүүлбэрийн цөм бүтцийг зөв зурсан бол 1 оноо, зөв тодорхойлсан бол 1 оноо

**4.** Жинхэнэ нэрийн тийн ялгалаар хувиргаарай. /2 оноо/

- Тийн ялгалын нөхцөл бүрийг зөв дагуулсан бичсэн бол 0.5 оноо.
- тийн ялгалын нөхцөлийг буруу залган бичсэн бол 0 оноо

**5.** Дараах үгийг зөв бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг зөв тайлбарлаж дэлгэрэнгүй бичсэн бол 1 оноо
- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо
- Үгийг буруу бичсэн бол 0 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо

**6.** Зохиолын хэсгийг уншаад зохиолч болон зохиолын нэрийг нөхөөрэй. /5 оноо/

- Зохиолч болон зохиолчийн нэрийг зөв бичих тус бүрт 0.5 оноо
- Зохиолч болон зохиолчийн нэрийг буруу бичсэн хариулт тус бүрт 0 оноо

**7.** Монгол бичгээр бичсэн өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

- Зөв уншсан үг, дагуулан бичсэн нөхцөл бүрт 0.3 оноо

Нийт 20 оноо

**6-р ангийн анги дэвших шалгалтын материалын аргачлал**

Хувилбар-А Хугацаа: 60 мин 2024.05.28

8. Дээрх эхийн гол санааг тодорхойлон бичнэ үү? /1 оноо/

   Зөв хариулт: Дээрх эхийн гол санаа нь амьтныг хайрлах сэтгэлийн тухай юм.

- Эхийн гол санааг зөв оновчтой дэлгэрэнгүй тайлбарласан бол 1 оноо.
- Эхийн гол санааг дутуу тайлбарласан бол 0.5 оноо
- Эхийн гол санааг оновчгүй тайлбарласан бол 0 оноо

Ах дүү хоёр яагаад болжморт үүр хийж өгсөн бэ? /1 оноо/

- Ах дүү хоёр болжморыг даарч байгаа байх гэж өрөвдөж хайрласан тул үүр хийж өгсөн.
- Шалтгааныг зөв оновчтой дэлгэрэнгүй тайлбарласан бол 1 оноо.
- Шалтгааныг дутуу тайлбарласан бол 0.5 оноо
- Шалтгааныг оновчгүй тайлбарласан бол 0 оноо

9. Таамагласан утга бүхий өгүүлбэр аль нь вэ? /2 оноо/

   Зөв хариулт: ....шувууны найр болж байгаа бололтой.

   - Таамагласан өгүүлбэрийг зөв бичсэн бол 2 оноо
   - Таамагласан өгүүлбэрийг дутуу бичсэн бол 1 оноо
   - Таамагласан өгүүлбэрийг буруу бичсэн бол 0 оноо

10. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, цөм бүтцийг тодорхойлон бичээрэй. /2 оноо/

    Ээж өнөөдөр миний хөөрхөн найзыг гэртээ дуудав.

    Зөв хариулт:

- Ээж найзыг дуудав.
- 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр
- Өгүүлбэрийн цөм бүтцийг зөв зурсан бол 1 оноо, зөв тодорхойлсон бол 1 оноо

11. “Хадлан” хэмээх үгийг жинхэнэ нэрийн тийн ялгалаар хувиргаарай. /2 оноо/

| | |
|---|---|
| Нэрлэх- хадланг | Гарах- хадлангаас |
| Харьяалах- хадлангийн | Үйлдэх- хадлангаар |
| Өгөх орших- хадланд | Хамтрах- хадлантай |
| Заах- хадланг | Чиглэх- хадлан руу |

- Тийн ялгалын нөхцөл бүрийг зөв дагуулсан бичсэн бол 0.5 оноо.
- тийн ялгалын нөхцөлийг буруу залган бичсэн бол 0 оноо

12. Дараах үгийг зөв бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Захь+дал= захидал

ЗБД: 9+9=и 3Г-ээр төгссөн үгэнд 3Г-ээр эхэлсэн залгавар залгахад "Ь" нь "И" болно.

- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг зөв тайлбарлаж дэлгэрэнгүй бичсэн бол 1 оноо
- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо
- Үгийг буруу бичсэн бол 0 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо

13. Зохиолын хэсгийг уншаад зохиолчийн нэр болон зохиолын нэрийг нөхөөрэй. /5 оноо/

| Зохиолын хэсэг | Зохиолч | Зохиолын нэр |
| --- | --- | --- |
| Эгшин бүрийнд цэгнүүштэй нь<br>Бие, хэл, сэтгэл гурав .... | Данзанравжаа | Гурван сүлжээ сургаал |
| ... Дайраад гарах нүүдлийг<br>Ээж минь амдан гүйнэм. | С.Дулам | Нүүдлийн цай |
| Ивээлт нарны нь цацрал алтан<br>эрдэнэ .... | П.Бадарч | Есөн эрдэнэ |
| ...Хатируулснаа шогшуууллаа<br>Шогшуулснаа алхууллаа. | Ж.Дашдондог | Аранзал зээрд |
| ..Монголын үзэсгэлэнт сарангоо ... | Д.Нацагдорж | Миний ижий |

- Зохиолч болон зохиолчийн нэрийг зөв бичих тус бүрт 0.5 оноо
- Зохиолч болон зохиолчийн нэрийг буруу бичсэн хариулт тус бүрт 0 оноо

14. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

ᠥᠰᠬᠦ ᠨᠠᠰᠤᠨ ᠳᠠᠭᠠᠨ ᠰᠤᠷᠤᠭᠰᠠᠨ
ᠡᠷᠳᠡᠮ ᠤᠷᠭᠤᠬᠤ ᠨᠠᠷᠠ ᠮᠡᠲᠦ᠄
ᠢᠳᠡᠷ ᠨᠠᠰᠤᠨ ᠳᠠᠭᠠᠨ ᠰᠤᠷᠤᠭᠰᠠᠨ
ᠡᠷᠳᠡᠮ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠨᠠᠷᠠ
ᠮᠡᠲᠦ᠄

Өсөх насандаа сурсан эрдэм ургах наран адил.

Идэр насандаа сурсан эрдэм үдийн наран

- Зөв уншсан үг бүрт 0.3 оноо

Нийт 20 оноо

6-р ангийн анги дэвших шалгалтын материалын аргачлал

Хувилбар-Б Хугацаа: 60 мин 2024.05.28

1. Эхийн гол санааг илэрхийлэн бичээрэй. /1 оноо/

   Зөв хариулт- Эхийн гол санаа нь эх үрийн хайрлах сэтгэлийн тухай юм.

   - Эхийн гол санааг зөв оновчтой тодорхойлж, бүтэн өгүүлбэрээр хариулсан бол 1 оноо
   - Эхийн гол санааг дөхүүлэн тайлбарласан бол 0.5 оноо
   - Эхийн гол санааг буруу тайлбарлсан бол 0 оноо

   Могой яагаад жинчдийн ачаа барааны дэргэд хэвтсэн бэ? /1оноо/

   Зөв хариулт: Могойны зулзага нь жинчдын ачаа барааны дэргэд хэвтэж байсан тул тэрээр дэргэд нь хэвтэж байсан.

- Шалтгааныг оновчтой зөв тодорхойлж бүтэн өгүүлбэрээр хариулсан бол 1оноо
- Шалтгааныг цөөн үгээр зөв тодорхойлсон бол 0.5 оноо
- Буруу тайлбарласан бол 0 оноо

2. Таамагласан утга бүхий өгүүлбэрийн хэсэг аль нь вэ? /2 оноо/

   Зөв хариулт нь: Энд л нэг учир байна даа

   - Таамагласан өгүүлбэрийг зөв бичсэн бол 2 оноо
   - Таамагласан өгүүлбэрийг дутуу бичсэн бол 1 оноо
   - Таамагласан өгүүлбэрийг буруу бичсэн бол 0 оноо

3. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, цөм бүтцийг тодорхойлон бичээрэй. /2 оноо/

   Би өчигдөр аавын дурангаар хөөрхөн янзагуудыг дурандав.

   - Би янзагуудыг дурандав.
   - Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр
   - Өгүүлбэрийн цөм бүтцийг зөв зурсан бол 1 оноо, зөв тодорхойлсон бол 1 оноо

4. “<u>Морь</u>” хэмээх үгийг жинхэнэ нэрийн тийн ялгалаар хувиргаарай. /2 оноо/

   Нэрлэх- морь Гарах- мориноос

   Харьяалах- морины Үйлдэх- мориор

   Өгөх орших- моринд Хамтрах- морьтой

   Заах- морийг Чиглэх- морь руу

   - Тийн ялгалын нөхцөл бүрийг зөв дагуулсан бичсэн бол 0.5 оноо.
   - тийн ялгалын нөхцөлийг буруу залган бичсэн бол 0 оноо

5. Дараах үгийг зөв бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Барь+мал=баримал

ЗБД: 7+7=и ЭГ-ээр төгссөн үгэнд ЭГ-ээр эхэлсэн залгавар залгахад “Ь” нь “И” болно.

- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг зөв тайлбарлаж дэлгэрэнгүй бичсэн бол 1 оноо
- Үгийг зөв бичсэн бол 1 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо
- Үгийг буруу бичсэн бол 0 оноо, дүрмийг тулгуур бичиглэлээр зөв бичсэн бол 0.5 оноо

6. Зохиолын хэсгийг уншаад зохиолч болон зохиолын нэрийг нөхөөрэй. /2 оноо/

| Зохиолын хэсэг | Зохиолч | Зохиолын нэр |
|---|---|---|
| Эрт цагт нэгэн эцгийн хоёр хүүхэд холын уулнаас | П.Хорлоо | Алт мөнгө хоёр |
| ... Удам чинь улам олшрог гэж баярлан хашхирав. ... | Д.Давааням | Зүрх цагаан |
| ...эцсийн эцэст өөрийн эрхгүй сөгдөн шургачиж хэвтлээ. ... | Ч.Лодойдамба | Шаргачин |
| Үрийн сайнаар ургаж Үндэсний муугаар ховхорлоо ... | Хуульч Сандаг | Салхинд хийссэн хамхуулны үг |
| Хэдэн хүүхдийн минь хайртай ат юм сан | Л.Одончимэд | Хүүхдийн бор |

- Зохиолч болон зохиолчийн нэрийг зөв бичих тус бүрт 0.5 оноо
- Зохиолч болон зохиолчийн нэрийг буруу бичсэн хариулт тус бүрт 0 оноо

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

ᠵᠥᠭᠡᠯᠡᠨ ᠦᠭᠡᠨ ᠳᠦ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠦᠬᠦᠨ
ᠪᠥᠬᠡᠢᠢᠨ᠎ᠡ ᠂ ᠵᠦᠯᠦᠭ ᠭᠠᠵᠠᠷ ᠲᠤ
ᠮᠣᠷᠢ ᠪᠦᠬᠦᠨ ᠬᠥᠷᠪᠡᠢᠢᠨ᠎ᠡ ᠃
ᠶᠠᠪᠤᠭᠰᠠᠨ ᠨᠣᠬᠠᠢ ᠶᠠᠰᠤ ᠵᠠᠭᠤᠨ᠎ᠠ ᠃

Зөөлөн үгэнд хүн бүхэн бөхийнө, зүлэг газарт морь бүхэн хөрвөөнө. Явсан нохой яс зууна.

- Зөв уншсан үг бүрт 0.3 оноо

Нийт 20 оноо